

2025 / 3 / 17

№ 25/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, 76.1.6 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (“Компани”)–ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)–ийн эчнээ санал хураалтын шийдвэрийн дагуу

ТОГТООХ НЬ:

1. Компанийн болон нэгдлийн оролцогч компаниудын эзэмшиж буй Ард Даатгал ХК–ийн нийт гаргасан хувьцааны 50 хувьтай тэнцэх хувьцааны нийт үнэлгээг 20,000,000,000 (хорин тэрбум) байхаар **ТОГТООСУГАЙ;**
2. Тогтоолын нэг дэх хэсэгт заасан хувьцааг Компанийн холбогдох этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн худалдах хэлцэл хийхийг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ;**
3. Хувьцааны арилжааг гүйцэтгэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон ханшаас багагүй үнийн дүнгээр гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)–д үүрэг **БОЛГОСУГАЙ;**
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийг төлөөлөн холбогдох гэрээ хэлцлийг байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)–д **ДААЛГАСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ